



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 13, 15140-0036
Утас/Факс: (976-11) 31-83-92
E-mail: nok@ulaanbaatar.mn
http://www.nobg.ub.gov.mn

2021. 11. 24 № 923

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Нийслэлийн хэмжээнд “Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөө”-г гарган хүргүүлж байна.


Төлөвлөгөөнд тусгасан ажлыг заалт тус бүрээр хэрэгжүүлэн, үр дүнг тооцож ажиллана уу.

Хавсралт 4 хуудастай.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУРАНДАА Д.ОЮУНБАТ



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН НЭГДСЭН
ШУУРХАЙ ШТАБЫН ОРЛОГЧ
ДАРГА



Р.ДАГВА

2021 оны 11 дүгээр сарын 23 -ны өдөр

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ДАРХЛАА СЭРГЭЭХ НЭМЭЛТ ТУНГААР
ВАКЦИНЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага, албан тушаалтан	Хүрэх үр дүн
Нэг. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэхэд салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах					
1.1	Бүх төрлийн баар, ресторан кафе, амралт, жуулчны газар, фитнес, бассейн, спортын арга хэмжээ, үзвэр, үйлчилгээний байгууллагууд дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсан иргэдэд үйлчлэх шийдвэрийг гаргуулах	2021.11.23	УОК-ын НШШ НЗДТГ	ЭМЯ	Иргэдийг дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулах боломж бүрдэнэ
1.2	Их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутан суралцагчдын дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2021.11.23- 12.31	УОК-ын НШШ НОК ШШ	БШУЯ	Оюутан суралцагчдын дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдалт нэмэгдэнэ
1.3	Хариуцлагын гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад эрчимжүүлсэн хяналт шалгалтыг зохион байгуулж, Нэгдсэн шуурхай штабт 7 хоног бүр тайлагнах	2021.11.23- 12.31	НОК ШШ УБЗАА НМХГ НЦУГ НСУГ НСХ НАЖГ	Дүүргийн Онцгой комисс, үзвэр үйлчилгээ, худалдаа үйлчилгээ, спортын арга хэмжээ зохион байгуулж буй байгууллагууд	Халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилт хангагдана

1.4	Нутгийн захиргааны байгууллагууд халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж, шаардлагатай тохиолдолд цахимаар ажиллуулах боломжийг бүрдүүлэх	Тухай бүр	Нутгийн захиргааны бүх байгууллага	-	Төрийн албан хаагчдын дунд халдвар тархах эрсдэл буурна
1.5	Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг ажлын нэг өдрийн чөлөө олгож дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах, хамрагдаагүй шалтгааны талаарх албан хаагчдын судалгаа гаргаж НОКШШ ирүүлэх	2021.11.23-12.01	НЗДТГ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд	Дүүргийн Засаг дарга нар	Ажилтан, албан хаагчдыг дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсаны дараа нэг өдрийн дэглэм барих, ажиглах боломж бүрдэж, халдвар тархах эрсдэлийг бууруулна
1.6	Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд ажилтан албан хаагчдаа дархлаа сэргээх нэмэлт тунд хамруулах талаар уриалж, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2021.11.23-12.31	Хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд	ДОК ШШ, байгууллага, аж ахуйн нэгжүүд	Дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамралт нэмэгдэнэ
1.7	Иргэд олноор үйлчлүүлдэг томоохон зах худалдааны төвүүдэд цэг байгуулж, худалдаачид, үйлчлүүлэгчдийг дархлаажуулатад хамруулах боломжийг нэмэгдүүлэх	2021.11.23-12.31	НОК ШШ, Төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүд	ДОК ШШ, байгууллага, аж ахуйн нэгжүүд	Иргэд, үйлчлүүлэгчдэд дархлаажуулалтын цэгийг ойртуулснаар хамрагдах боломж нэмэгдэнэ
1.8	Дархлаа сэргээх нэмэлт тунгийн дархлаажуулалтын цэгт хяналт тавих, зөвлөн туслах үйл ажиллагааны нэгдсэн хуваарь батлуулах	2021.11.25	УОКНШШ НОК ШШ ДОК ШШ	Байгууллага, аж ахуйн нэгжүүд	Дархлаажуулалтын цэгт холбогдох тушаал, шийдвэр халдвар хамгааллын дэглэм мөрдөлт сайжирна
1.9	Бүх хороодод /171/ дархлаажуулалтын цэг ажиллуулах тул хороодын хүн амыг идэвхтэй хамруулах ажлыг хорооны Засаг дарга, түүний Ажлын албад хариуцан зохион байгуулах	2021.11.23-12.31	НЭМГ НОК ШШ	ДЗДТГ ДОК ШШ ДЭМТ	Дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамралт нэмэгдэнэ
Хоёр. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг эрүүл мэндийн байгууллагын дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх					
2.1	Дархлаа сэргээх нэмэлт тунгийн вакцинжуулалтыг эрчимжүүлэх хүрээнд шинээр байгуулагдсан явуулын болон түр цэгийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх	2021.11.23-12.31	ДОК ШШ, дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМГ	Иргэдийн дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамралт сайжирна.

2.2	Дархлаажуулалтын цэг, явуулын багт ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийг “Амилуулах суурь тусламж”-ийн сургалтад хамруулах	2021.11.18-11.30	Нийслэлийн Түргэн тусламжийн төв Дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМГ	Болзошгүй дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн үед яаралтай тусламж үзүүлэх мэдлэг, ур чадвар дээшилнэ
2.3	Дархлаажуулалтын цэгт ажиллах вакциначор сувилагчдын хүрэлцээг нэмэгдүүлэх, сургалтад хамруулах	2021.11.18-11.30	Дүүргийн эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв	ХӨСҮТ	Вакциначор сувилагчдын хүрэлцээ нэмэгдэнэ
2.4	Яаралтай тусламжийн эм хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх	2021.11.18-11.25	ДОК ШШ, дүүргийн эрүүл мэндийн төв	НЭМГ	Дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааны бэлэн байдал хангагдсан байна
Гурав. Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдах талаар иргэдэд чиглэсэн нөлөөллийг арга хэмжээ зохион байгуулах					
3.1	Нэмэлт тунгийн хамрагдалт, үр дүн, ач холбогдлын талаар мэргэжлийн судлаач, эрдэмтдийн ярилцлага, дархлаажуулалтын түр цэгт үйл явцын сурвалжилга, мэдээ мэдээлэл бэлтгэн телевиз, олон нийтийн сүлжээгээр түгээх	2021.11.23-12.31	НЭМГ НОК ШШ	Хэвлэл мэдээллийн баг	Дархлаа сэргээх нэмэлт тунгийн талаарх иргэдийн мэдээлэл нэмэгдэж, хамрагдалт өснө
3.2	Олны танил, нэр хүндтэй хүмүүсийг дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдахыг уриалсан утга бүхий нөлөөллийн үйл ажиллагаанд татан оролцуулах	2021.11.23-12.31	НЭМГ НОК ШШ	Хэвлэл мэдээллийн баг	Олон нийтийн сүлжээгээр түгээлтийг хийж, цаг алдалгүй мэдээлэл түгээснээр иргэдийн дархлаа сэргээх нэмэлт тунгийн хамрагдалт сайжирна
3.3	Дархлаа сэргээх нэмэлт тунгийн ач холбогдлыг сурталчилсан видео шторк, хэвлэлийн постер бэлтгэж, түгээх	2021.11.23-12.31	НЭМГ НОК ШШ	Хэвлэл мэдээллийн баг	Нэмэлт тунгийн ач холбогдол, үр дүнгийн талаар мэдээлэлтэй болно
3.4	Дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдахын ач холбогдлын талаар бусад улсын туршлага, эерэг талыг сурталчилсан мэдээлэл бүхий постер, хэвлэлийн тойм бэлтгэн түгээх	2021.11.23-12.25	НЭМГ НОК ШШ	Хэвлэл мэдээллийн баг	Бусад улсад хийгдэж буй вакцинжуулалтын явцын талаар мэдээлэл, харьцуулалттай болно
3.5	Томоохон зах, худалдааны төвүүдэд	2021.11.23-	НОК ШШ	УБЗАА	Иргэд дархлаажуулалтын

	хийгдэж байгаа дархлаажуулалтын цэгийн мэдээллийг уэль, чанга яригчаар шторк явуулж түгээх.	12.25	ДОК ШШ		цэгийн талаарх мэдээллээр хангагдана
3.6	Үүрэн холбооны оператор компаниудаар дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдах талаар иргэдэд багц мессэж хүргэх	2021.11.23-12.25	НОК ШШ	Мобиком Юнител, Скайтел, Жи мобайл ХХК	Иргэдийн дархлаажуулалтад хамрагдах идэвх нэмэгдэнэ
Дөрөв. Бусад					
4.1	Дархлаажуулалтын шаардлагатай зардлыг шийдвэрлүүлэх ажилд нэгтгэн	2021.11.23-12.25	НОК ШШ	НЗДТГ	Үйл ажиллагаа шуурхай зохион байгуулах нөхцөл бүрдэнэ

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБ